

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ  
ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН  
Ц.ДАМДИНСҮРЭНГИЙН ГЭР МУЗЕЙ



**Ц.ДАМДИНСҮРЭНГИЙН ГЭР МУЗЕЙН  
МОНГОЛ НОМ СУДРЫН БҮРТГЭЛ**

УЛААНБААТАР ХОТ  
2018 ОН

Шинжлэх ухааны академи  
Хэл зохиолын хүрээлэн  
Ц.Дамдинсүрэнгийн гэр музей

Г.Билгүүдэй, Р.Отгонбаатар, А.Цендина

# **Ц.ДАМДИНСҮРЭНГИЙН ГЭР МУЗЕЙН МОНГОЛ НОМ СУДРЫН БҮРТГЭЛ**

Нэмэлт галиг болон ном, зохиогчийн  
нэрсийн хэлхээг хийж, ариутган шүүсэн  
А.Туранская, Н.Ямпольская

Редактор С.Байгалсайхан

Улаанбаатар хот  
2018

ННА 72  
ДАА 378.121  
Б-48

Г.Билгүүдэй, Р.Отгонбаатар, А.Цендина

## Ц.ДАМДИНСҮРЭНГИЙН ГЭР МУЗЕЙН МОНГОЛ НОМ СУДРЫН БҮРТГЭЛ

Нэмэлт галиг болон ном, зохиогчийн  
нэрсийн хэлхээг хийж, ариутган шүүсэн:

А.Туранская, Н.Ямпольская

Редактор:

С.Байгалсайхан

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

Т.Түвшинжаргал

Хавтасны дизайнер:

Б.Эрдэнэбулган

Цаасны хэмжээ:

70x100/16

Хэвлэлийн хуудас:

51.66

ISBN:978-99978-768-0-5



“Соёмбо Принтинг” ХХК-д  
хэвлэв.

## ГАРЧИГ

Өмнөх үг .....	4
I. Ганжуурын ном.....	7
II. Лам нарын бурхан шашны онол туурвил.....	77
III. Намтар.....	119
IV. Цадиг, үлгэр, тууж, тууль, домог.....	183
V. Сургаал, тайлбар.....	228
VI. Бошиг лүндэн.....	301
VII. Уншлагын ерөөл, магтаал, залбирал, мөргөл .....	307
VIII. Бурхан шашны зан үйл .....	348
IX. Ардын заншил, шүтлэг.....	385
X. Төр, шашны түүх.....	399
XI. Хууль цааз, албан бичиг, захидал .....	443
XII. Анагаах ухаан, эм дом.....	450
XIII. Зурхай, мэргэ төлгө.....	455
XIV. Хэл зүй, толь бичиг, гарчиг.....	474
XV. Хятад зохиолын орчуулга .....	513
XVI. Элдэв зүйл .....	534
Ном зүй .....	542
Ном судрын монгол нэр.....	543
Ном судрын төвд нэр .....	579
Тод үсгийн ном судрын нэр.....	583
Номын шифрийг бүртгэлийн дугаартай харгуулсан хүснэг .....	594
Бүртгэлийн анхны хэвлэлийн номын дугаартай харгуулсан хүснэг .....	608

## ӨМНӨХ ҮГ

Ардын уран зохиолч, академич Цэндийн Дамдинсүрэнгийн мэндэлсний 110 жилийн ойг тохиолдуулж гэр музейд нь хадгалагдаж буй монгол дармал, бичмэл ном судрын гарчгийг дахин хэвлэж байна. Нэгдүгээр хэвлэл нь 1998 онд Ц.Дамдинсүрэнгийн мэндэлсний 90 жилийн ойгоор “Ц.Дамдинсүрэнгийн гэр музейн монгол номын бүртгэл. I боть” гэсэн гарчигтай гарсан бөгөөд тухайн үедээ цөөхөн хувь хэвлээд одоо олдохгүй болжээ. Энэ анхны хэвлэлд зарим судар давхацсан, гээгдсэн, ангилал хийхдээ ижил төрлийн номыг өөр өөр анги бүлэгт оруулсан зөрчил, мадагтай болсныг засаж залруулан шинээр ангилсан энэхүү дэвтрийг хэвлэв.

Нэгд, юуны өмнө шинэ хэвлэлийн гарчгийн ангиллыг өөрчилсөн болно. Ц.Дамдинсүрэнгийн гэр музейн ном судрууд хувь нэгэн эрдэмтэн хүний өөрийн сонирхлын дагуу цуглуулж хадгалсан хөмрөг болох учир олон улсын том номын сангийн гарчгийн зарчим арай таарахгүй байв. Тийм учраас нэгдүгээр хэвлэлийн ангиллыг өөрчилж, өмнөхөөс нэлээд ерөнхий боловч уг цуглуулгын онцлогт илүү тохиромжтой мэт санагдсан ангиллыг хийсэн юм. Хоёрдугаар хэвлэлийн ангилал нь дараах мэт болов.

- I. Ганжуурын ном
- II. Лам нарын бурхан шашны онол туурвил
- III. Намтар
- IV. Цадиг, үлгэр, тууж, тууль, домог
- V. Сургаал, тайлбар.
- VI. Бошиг лүндэн
- VII. Уншлагын ерөөл, магтаал, залбирал, мөргөл
- VIII. Бурхан шашны зан үйл
- IX. Ардын заншил, шүтлэг
- X. Төр, шашны түүх
- XI. Хууль цааз, албан бичиг, захидал
- XII. Анагаах ухаан, эм дом
- XIII. Зурхай, мэргэ төлгө
- XIV. Хэл зүй, толь бичиг, гарчиг
- XV. Хятад зохиолын орчуулга
- XVI. Элдэв зүйл болно.

Хоёрт, ном судрын төгсгөлийн үгийг нэмсэн юм. Цуглуулсан эзэн нь монгол номтой эрдэмтэй лам, орчуулагч гүүш нарын Монголын соёлд оруулсан хувь нэмрийг чухалчлан сонирхож байсан учир цуглуулгад нь төвд номын олон монгол орчуулга, хувилбар, бар дармал, гар бичмэл хадгалагдаж байна. Тэр бүхний тухай мэдээ ихэнхдээ төгсгөлийн үгэнд байдаг учир тэдгээр нь шинжлэх ухааны үүднээс чухал материал болно гэж үзээд ийнхүү нэмэв.

Гуравт, уг хөмрөгийн ном судрын дотор цаас, хавчуурга, хавтас, донторт олон тэмдэглэл хийж байснаас нэгдүгээр хэвлэлд заримыг нь оруулж чадаагүй. Энэ бол их

эрдэмтний өөрийнх нь эрдэм шинжилгээний ажилд хэрэглэж байсан эрхэм чухаг зүйл болохоос гадна дараа дараагийн эрдэмтэн нарт мөн үнэлж баршгүй туслах материал болох юм гэж үзээд энэхүү шинэ хэвлэлд тийм тэмдэглэлийг аль болох бүрэн хэмжээгээр оруулахыг хичээсэн билээ.

Дөрөвт, тус номын нэгдүгээр хэвлэлд ном давхацсанаас гадна зарим номыг дансны дугаарын дагуу бүлэг бүлгээр нь салгаж тусгай ном болгон оруулсныг өөрчилж нэг зохиолыг нэг дугаартай болгон өөрчлөв. Ингээд хуучин гарчигт ороогүй шинэ ном оруулж, зарим дармал бичмэл судрыг шинээр тодорхойлж, хуучин гарчигт салж тархсан хэсгийг нэгтгэж, бас хуучин нийлсэн зохиолуудыг салгасан учир хуучин, шинэ хэвлэлийн бүртгэлийн ном судрын тоо нэлээд зөрүүтэй болов. Энэ нь зарим тохиолдолд шифрыг сольж өөрчлөхөд хүргэв. Хуучин бүртгэлд нэг шифрээр орсон хоёр гурван зохиолыг салгахдаа (1), (2) гэсэн тэмдгийг нэмж шинэ шифр бий болгосон юм.

“Ганжуурын ном” гэсэн хэсэгт зохиолын дарааллыг монгол Ганжуурын дагуу тавив. Эмхэтгэл номыг эхний зохиолоор нь жагсаалтанд оруулав. Галиг дотор “ом мани падмэ хум” тарнийг [маани] гэж товчилж оруулав.

Ном нэг бүрийн тодруулгын өгүүллийн бүтцийн тухайд гэвэл тодруулгын эхний мөрөнд уул гарчгийн дагуух дугаар, хаалтан дотор нэгдүгээр хэвлэлийн гарчигт тус номд оноосон дугаар (тийм дугаар байхгүй бол энэ ном хуучин гарчигт ороогүй гэсэн үг), бүртгэлийн шифрийг оруулав. Дараагийн мөрөнд тус номын товч гарчиг буюу алдаршсан нэрийг шинэ үсгээр бичив. Гуравдугаар мөрөнд тус номын тодорхойлолт (дармал буюу гар бичмэл), хэлбэр (судар, нугалбар, дэвтэр), хэл (монголоос бусад хэлийг заана), хуудсын тоо (бүрэн бус, дутуу бол заана), хуудсын хэмжээ сантиметрээр (хаалтан дотор барын хайрцгийн болон эх бичгийн хэмжээ), хуудсын мөрийн тоо, цаасны гарал (орос, хятад, төвд), бичгийн хэрэгсэл (хулс, бийр, үзэг), бэхийн өнгө, хуудсын дугаарыг бичсэн хэл, тоо (монгол хэлээр дугаарласныг заагаагүй), захын гарчгийг оруулав.

Дараагийн мөрөнд гар бичмэл болон дармал судрын жинхэнэ нэрийг латин галигаар бичив. Хожуу үед нэмж бичээгүй бол хавтас хийгээд нүүрэн талд бичсэн гарчгийг чухал хэмээн үзэв. Хавтас, нүүр, эх болон төгсгөлд номын гарчгийг өөр өөрөөр бичсэн бол бүгдийг оруулав. Нэр гарчиггүй, эхний болон сүүлийн хуудсууд дутуу байх тохиолдолд эхний болон төгсгөлийн үгийг эхлэл: төгсгөл: гэсэн үгээр оруулсан билээ. Хуудсын дугаар болон талыг (жишээ нь [12г] гэж) дөрвөлжин хаалтанд заасан байна.

Номд заасан буюу бидний сэргээсэн санскрит, төвд, хятад зэрэг гарчгийг галиглаж тусгайд нь тавьсан юм. Хятад гарчгийг хятад ханз үсгээр тавив. Хадмал номын монгол гарчгийг эхэлж тавиад дараа нь төвд гарчгийг (байвал) тавьсан юм. Номын санскрит, төвд нэрийг эхлээд гарсан номд л тавив.

Үүний дараа төгсгөлийн үгийг бүрэн оруулав. Хоёр номын төгсгөлийн үг ижил байвал эхлээд бүрэн оруулж, дараагийн номд оруулахгүйгээр тийм тийм номтой ижил гэж заав. Нэмсэн зүйл байваас тэмдэглэн оруулсан болно. Төгсгөлийн үгийг төвд, монгол хоёр хэлээр бичсэн бол эхлээд монголыг, дараа нь төвдийг тавив. Номд хэд хэдэн зохиол орж ном бүр өөрийн төгсгөлийн үгтэй байвал, зохих байранд нь дэс дараагаар оруулав.

Түүний дараа зохиогч, дуртгагч, газар орон, он цаг зэрэг мэдээллийг төгсгөлийн үгэнд заасны дагуу байрлуулав.

Мөн тэмдэглэл: гэсэн гарчигтай энэ хэвлэлийн зохиогчийн тайлбарыг оруулав. Тэнд номын гэмтсэн байдал, хуудсын дугаарыг заасан өвөрмөц зүйл, бусад тайлбарыг бичив. Мөн тус номыг бусад цуглуулгын гол гол гарчигт заасныг мэдээлэв.

Хамгийн сүүлд Ц.Дамдинсүрэнгийн тэмдэглэлийг оруулав.

Галигийн тухайд бол монгол бичгийг олон улсын тогтсон ёсоор, төвд бичгийг Вайлийн системийг арай хялбарчилсан маягаар авсан билээ.

Шифрт ашигласан товчлолоо тайлбарлая:

А үсгээр номын авдрыг,

Ш үсгээр номыг шүүтгээг,

Ши үсгээр ширээний шургуулгыг,

ТТ үсгээр төмөр тавиурыг,

ХТ үсгээр номын ханын тавиурыг,

Шу үсгээр шургуулгыг тус тус тэмдэглэсэн болно.

Монгол номын бүртгэлд хэрэглэсэн техник товчлол:

бар. — модон бар

бур. — буриад

Бээж. — Бээжин

Өвөр. — Өвөрлөгч

гар бич. — гар бичмэл

зах. гарч. — захын гарчиг

з. — зууны үе

са. — санскрит

мо. — монгол

ойр. — ойрад

хят. — хятад

тө. — төвд

х. — хуудас

т. — тал

ц.х. — цэвэр хуудас

бич. — бичгийн

Тусгай тэмдэг:

{qayan} — тус үгийг мөрөн дотор оруулсан байна.

[qayan] — тус үгийг зохиогч сэргээн оруулав.

[...] — үг гээгдсэн байна.

<qayan> — тус үгийг хассан байна.

/ — хоёр мөрийн зааг.

(?) — эргэлзээтэй үг.

qagan — зөв бичих дүрмийг зөрчиж бичсэн үг.

(=qayan) — буруу бичсэн үгийн дараа хаалтанд зөв бичиж оруулав.